



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/565

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цамбагарав багын иргэн Ж.Батсүхэд 150 000 төгрөгийн буцалтгүй тусламж, донор гэр бүлд өргөмжлөл хийлгэсэн зардалд 10 000 төгрөг, Хүндэт өргөмжлөл 87 ширхэгийг захиалан хийлгэх зардалд 1 044 000 төгрөг, Монголын язгуур угсаа, соёл уламжлалаа түгээн дэлгэрүүлэх зорилгоор туурвисан Зураач Ж.Ганбатын “Монгол үндэсний хувцас” номыг 10 ширхэгийг худалдан авахад 1200 000 төгрөгийг тус тус зарцуулсугай

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 2 404 000 төгрөг /Хоёр сая дөрвөн зуун дөрвөн мянган/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д, үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/565 Ch
02 02946